

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г. БАТХИШИГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
НЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 1: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.							
1.	Арга хэмжээ-1.1: Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороонд байрлах Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш, орчны тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	80%	100%	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/219, А/926 дугаар захирамжаар түүх соёлын дурсгалт газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар гадаад дотоодын жуулчдын зорин очих газрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотоос 22 км зайд Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор тохижилтын ажлыг Нийслэлийн Аялал жуулчлалын газраас Унгарын улсын элчин сайдын яам, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай хамтран тохижилтын ажлыг 2022 оноос эхлүүлэн “Өндөрхаан-Өргөө”ХХК-тай хамтран 2024 оны 10 дугаар сард хийж гүйцэтгэж дууссан.	2024.08.16- 2024.12.05	100 %

004

					2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус түүхэн дурсгалт газарт Унгарын улсын элчин сайдын яамнаас “Атиллагийн багана” буюу хамтарсан экспедицийн малтлагыг мөнхжүүлсэн “Дурсгалын хөшөөг” сүндэрлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оролцсон. Түүнчлэн Улаанбаатар хотод байрлаж буй Хүннүгийн үеэс олдсон анхны түүх соёлын дурсгал тул ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс Дэлхийн өвд бүртгүүлэхээр ЮНЕСКО-д хандаад байгаа.		
2.	Арга хэмжээ-1.2: “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтчийн төлөвлөгөө гаргах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	20%	100%	“Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтчийн төлөвлөгөөг батлуулсан.	2024.08.19	100 %
3.	Арга хэмжээ-1.3: “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтчийн төлөвлөгөөний дагуу гэрээ хийх	Гэрээний тоо	1	6	Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтчийн төлөвлөгөөний дагуу 6 гэрээг хийсэн.	2024.08.16- 2024.12.05	100 %
	Арга хэмжээ-1.4: “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн		-	100%	Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/849 захирамжийн хүрээнд Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар	2024.08.16- 2024.12.05	95 %

101

4.	хөтчийн гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь			360 хөтөч" гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд алхалтын 15 маршрутыг нээж, зам маршрутыг заах мэдээллийн 50 самбарыг байршуулсан. Үүнд: 1. Хүннү цогцолбор 2. Их баян санзай 3. Хадат 4. Хайрхан хөгжлийн төв-Шүтээн цогцолбор 5. Асралт хайрханы бараа 6. Ямаат уулын алхалтын зам 7. Тэрэлж-Аръяабалын хийд алхалт 8. Зүрхэн оргил 9. Шадивлан-Чингэлтэй 10. Бэлх 11. Доод салхитын зогсоол-зүрх уул 12. Хандгайт 13. Хиймэл ойн зурвас 14. Хиймэл нуур-хадтай ой 15. Арцатын ам-Богд уулын оргил гэх мэт маршрутуудыг нээсэн.		
5.	Арга хэмжээ-1.5: Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Койка олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд сайн дурын ажилтныг ажиллуулан харилцан туршлага судлан ажиллаж байна. КОЙКА, ЖАЙКА зэрэг олон улсын байгууллагуудад хамтран ажиллах боломжтой 2 төслийн саналыг боловсруулан хүргүүлэв. Төслийн хүрээнд 1700\$-ийн дэмжлэг үзүүлж сурталчилгааны сэтгүүл хэвлүүлэв. Мөн цаашид Сургалт судалдгааны төв ашиглалтад орж байгаатай холбогдуулан салбарын ажилтнуудыг мэргэжүүлэх сургалтуудыг шат дараатай хамтран зохион байгуулахаар болов.	2024.08.16- 2024.12.05	80 %

100

					Плэйтийм ногоон хүрээлэн төсөл дээр 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр сэргээгдэх эрчим хүч төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр “1737 энтертаймент” ХХК-ийн Minister tower-ын 701 тоотод Захирал Ц.Нацагдорж, Үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Оюунномин, Артистик директор Б.Батгэрэл, Италийн Mad.e компанийн co-founder Данте, Newcom группийн Дэд бүтцийн асуудал хариуцсан захирал Ганхуяг, Эрчим хүчний төслийн захирал Т.Хишигт, Манай газрын Дарга Д.Батсүх, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул нартай хамтран уулзалт зохион байгуулахад оролцсон.		
6.	Арга хэмжээ-1.6: Байгууллагаас зохион байгуулж буй эвент арга хэмжээнүүдийн үеэр хариуцсан үүрэг чиглэлийн дагуу ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын явган алхалтын холбоо, “Монгол Оллз” нийгэмлэгтэй 2024 оны 8 дугаар сарын 23- 25-ны өдрүүдэд “Улаанбаатар явган алхалтын фестиваль 2024” арга хэмжээг Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул, Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн Б.Отгонбилэг нартай хамтран зохион байгуулсан. Явган алхалтын Фестивальд оролцохоор Англи, Герман, АНУ, Тайвань, Филиппин, Чех, ОХУ, Австрали, Казахстан, Япон, БНСУ зэрэг улсын 120 гаран явган алхагчид хүрэлцэн ирж байгаа бол Монгол улсаас 400 гаруй явган алхагчид оролцсон. • 8-р сарын 23-ны өдөр Налайх дүүрэг, Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Өгөөмөрийн ам, “Монгол оллз” 3-р маршрут	2024.08.23-25	100 %

501

					• 8-р сарын 24-ний өдөр Налайх дүүрэг, Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Чингис уул, "Монгол оллэ" 2-р маршрут, • 8-р сарын 25-ны өдөр Улаанбаатар хот доторх алхалт буюу "Жанжин Д.Сүхбаатарын талбайгаас – Скай ресорт" цанын бааз гэсэн маршрутаар алхсан.		
Зорилт 2: 3.4.2. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.							
3.4.4.1 "Найрсаг Улаанбаатар арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.							
7.	Арга хэмжээ-1.2.1: Жуулчдад зориулсан шөнийн худалдаа, үйлчилгээний гудамжтай болох;	Гудамжны тоо	-	1	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороонд байрлах Нийслэлийн өмчийн III байр буюу "Урт цагаан" худалдаа, үйлчилгээний төвийн дахин төлөвлөлтийн талаар иргэдээс санал авахад 96 хувь нь цэцэрлэгт хүрээлэн байгуулахыг дэмжсэнээр тус барилгыг буулгаж, чөлөөлсөн. Иргэдийн санал хүсэлтийн дагуу чөлөөлсөн 1.3 га талбайд авто машины далд зогсоолтой, дээрээ ногоон байгууламжтай цэцэрлэгт хүрээлэн байгуулах зураг төсөл боловсруулсан байна. Зураг төсөлд гурван давхар үйлчилгээний төв, далд, ил зогсоол, задгай мини театр, дугуйн зогсоол, усан оргилуур зэргийг төлөвлөсөн байна. Тус гудамжийг жуулчны гудамж болгон төлөвлөх талаар саналыг Зураг төслийн хүрээлэнд хүргүүлэн ажилласан. 2024 оны 12 сард тус гудамжийн тохижилтын ажлын хүрээнд ариун цэврийн байгууламж төлөвлөх, жуулчны мэдээллийн төвийн талбайг нэмж тусгах саналын албн бичгийг боловсруулан	2024.08.16- 2024.12.05	70 %

117

					Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т хүргүүлэн ажилласан.		
8.	Арга хэмжээ-1.2.2: Дүүргүүдийн аялал жуулчлалын дүр төрхийг тодорхойлж, брэндинг бий болгох,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	1	Нийслэлийн 9 дүүрэгт аялал жуулчлалын дүр төрхийг тодорхойлж, брэндиг бий болгох саналыг хүргүүлэн ажилласан. Брэндиг бий болгох ажлын хүрээнд судалгааны ажил хийгдэж байна.	2024.08.16- 2024.12.05	70 %
9.	Арга хэмжээ-1.2.3: Түүхэн дурсгалт газруудад бүтээн байгуулалт хийж, соёлын үл хөдлөх дурсгалуудыг түшиглэн он цагийн аялал зохион байгуулах	Маршрутын тоо	-	1	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Бэлхийн амны Хүннүгийн цогцолборт, Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд аялалын маршрут 15 нээсэн. 2025 оны явган алхалтын фестивальд маршрутыг оруулан он цагийн аялал хийхээр төлөвлөсөн.	2024.08.16- 2024.12.05	60 %
10.	Арга хэмжээ-1.2.4: Визит Улаанбаатар брэнд бүтээгдэхүүн бий болгох ажлыг үргэлжлүүлэх	Бүтээгдэхүүн й тоо	10	12	1.“Visit Ulaanbaatar” логог Улаанбаатар хотын сэтгүүл, хөтөч ном, нийслэл хотын газрын зураг зэрэг 3 төрлийн сурталчилгааны материал, 2 төрлийн бүтээгдэхүүн болон эвент арга хэмжээнүүдийн танилцуулга, контентуудад байршуулан олон нийтэд сурталчилсан. Мөн Visit Ulaanbaatar логотой шоколад, фудволк, халуун баригч савыг Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид зах зээлд нэвтрүүлэн худалдан борлуулж байна.	2024.08.16- 2024.12.05	80 %
ХОЁР. “БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ.” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмжээ-2.1: Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас	Тоо	-	шийдвэрл эсэн байна.	Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас өргөдөл, гомдол ирээгүй.	2024.08.16- 2024.12.05	100 %

58

11.	ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх				Төрийн болон аж ахуй нэгж байгууллагаас ирсэн 15 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Мөн хариуцсан ажлын хүрээнд 11 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад явуулан хамтран ажилласан.		
12.	Арга хэмжээ-2.2: Хэлтсийн тайлан мэдээг сар, улирал, жилээр гаргаж тайлагнах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн тайлан, мэдээг сар, улирал, жилээр гаргаж Захиргааны, санхүүгийн хэлтэст хүргүүлэн ажилласан.	2024.08.16- 2024.12.05	98 %
13.	Арга хэмжээ-2.3: Шуурхайн үүрэг даалгаврыг цаг тухай бүр тайлагнаж ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	100%	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр гаргаж Захиргаа, санхүүгийн хэлтэст өгсөн.	2024.08.16- 2024.12.05	100 %
3 ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Газрын дүрмийн 4.1.12. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;							
14.	Арга хэмжээ-3.1: Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100%	“Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн санг үүсгэн ажилласан. Үүнд: Нийт аяллын 15 маршрутын нээсэн. Ургамал, амьтад, байгалийн зургийн цахимжуулсан.	2024.08.16- 2024.12.05	100 %
ДӨРӨВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмжээ-4.1: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг	Хэрэгжилтийн хувь	-	100%	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажилласан.	2024.08.16- 2024.12.05	100 %

15.	хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн хэрэгжүүлж ажиллах						
16.	Арга хэмжээ-4.3: Архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи хууль тогтоомж, дүрэм журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, заавар, стандартыг хэрэгжүүлнэ.	-	100%	Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль болон бусад холбогдох дүрэмж, журмыг баримтлан заавар, стандартын дагуу хэрэгжүүлэн ажилласан.	2024.08.16- 2024.12.05	100 %
17.	Арга хэмжээ 4.4: Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах	Хэрэгжилтийн хувь	-	100%	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	2024.08.16- 2024.12.05	100 %

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар			Хүрэх түвшин		
-----	-----------------	--	--	--------------	--	--

	(арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Плэйтийм ногоон хүрээлэн төсөл, Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар гаргуулах	Хэрэгжилтийн хувь	-	100 %	Плэйтийм ногоон хүрээлэн төслийн хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 02/382 дугаар тохижилтийн ажлыг саналыг хүргүүлэн ажиллаж 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар гаргуулсан.	2024.08.16- 2024.12.05	100 %
2.	Арга хэмжээ 2. Плэйтийм ногоон хүрээлэнгийн авто зам барих тохижилтын ажлыг төсвийн саналыг Нийслэлийн зам хөгжлийн газарт хүргүүлэн тус газрын 2025 оны төсөвт тусгуулах	Хэрэгжилтийн хувь	-	100 %	Плэйтиймын ногоон хүрээлэн төслийн хүрээнд тохижилтын ажлын даалгаврыг Нийслэлийн зам хөгжлийн газрын 2025 оны төсөвт тусгуулахаар манай газрын 02/382 дугаар албан бичгийн хүргүүлэн 2025 оны тухайн байгууллагын төсөвт тусгуулан ажилласан.	2024.08.16- 2024.11.20	100 %

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		

801

	сайжруулах арга хэмжээ						
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан асуудлын хүрээнд шинэчлэн гарсан хууль, дүрэм, журмыг судлах.	Шинэчлэн гарсан хууль эрх зүйн мэдээлэлтэй болно.	-	Уншиж судалсан хуулийн тэмдэглэл хөтлөсөн байна.	Төрийн албаны тухай хууль /шиэчилсэн найруулга/, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг уншиж судаллаж, тэмдэглэл хөтөлсөн.	2024.08.16- 2024.12.05	100 %
2.	Арга хэмжээ 2. "Нийслэл-385" ментрошип хөтөлбөрт хамрагдаж суралцах	Мэдлэг ур чадвар нэмэгдсэн байна.	-	Ментигийн сургалтад амжилттай суралцсан байна.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэл хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж буй нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын идэвх оролцоо, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой "Нийслэл-385" Менторшип хөтөлбөр хамрагдан суралцаж Түгжрэлтгүй хот бичил төсөл дээр амжилттай ажиллаж төгссөн .	224.09,30- 2024.10.24	100 %
3.	Арга хэмжээ 3. Монгол бичгийн чадвараа дээшлүүлж, өөрөө бие даан суралцах.	Монгол бичгийн уншиж, бичиж сурна.	-	Монгол бичгийн чадвараа дээшүүлсэн байна.	Монгол бичгийн сургалтанд 09-10 сар хүртэл цахимаар 1 сар хамрагдаж сурсан.	2024.09- 2024.10	90 %
4.	Арга хэмжээ 4. Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага	Мэдлэг ур чадвар нэмэгдсэн байна.	-	-	"Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага" танхимын сургалт 2024 оны 11 дүгээр сарын 13 өдөр Удирдлагын академийн хичээлийн төв байранд 8 цагийн сургалтанд хамрагдсан.	2024.11.13	100 %

	сургалтад суралцах						
5.	Арга хэмжээ 5. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэгтэй болно.	-	-	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж сурсан.	2024.11.20	100 %
6.							

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, Төсөл
хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

 / Г.Батхишиг /

(Нэр, гарын үсэг)

 12 05

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
(Албан тушаал)

..... / С.Туул /

(Нэр, гарын үсэг)

.....

(Огноо)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ
ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Г.Батхишиг

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 09 сарын 18 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай	Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар
Зорилт 1: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.			
1.	Арга хэмжээ-1.5: Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		
3.4.4.1 “Найрсаг Улаанбаатар арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.			
2.	Арга хэмжээ-1.2.1: Жуулчдад зориулсан шөнийн худалдаа, үйлчилгээний гудамжтай болох;		Эдгээр үүрэгтэй холбоотой төсвийн зардал зарцуулах
3.	Арга хэмжээ-1.2.2: Дүүргүүдийн аялал жуулчлалын дүр төрхийг тодорхойлж, брэндинг бий болгох,		
4.	Арга хэмжээ-1.2.3: Түүхэн дурсгалт газруудад бүтээн байгуулалт хийж, соёлын үл хөдлөх дурсгалуудыг түшиглэн он цагийн аялал зохион байгуулах		Тогтвортой нийгмийн газруудын аялал газар болгон зарцуулах
5.	Арга хэмжээ-1.2.4:		

	Визит Улаанбаатар брэнд бүтээгдэхүүн бий болгох ажлыг үргэлжлүүлэх		
--	---	--	--

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

(Албан тушаал)

.....*А.Туул*..... /С.ТУУЛ/

(Нэр, гарын үсэг)

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ
ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Г.Батхишиг

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 08 сарын 19 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай	Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар
Зорилт 1: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.			
1.	Арга хэмжээ-1.6: Байгууллагаас зохион байгуулж буй эвент арга хэмжээнүүдийн үеэр хариуцсан үүрэг чиглэлийн дагуу ажиллах		Улаанбаатар нь гол аялал төв арга хэмжээг эрчимжүүлэх

ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

(Албан тушаал)

..... /С.ТУУЛ/

(Нэр, гарын үсэг)